

“АЛТАНБУЛАГ” ЧӨЛӨӨТ БҮСИЙН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБА



# ТОВЧ ТАЙЛАН

2020 он



## НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

### 1.1 Бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилт

1. Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 105 дугаартай тогтоолын хавсралтаар “Чөлөөт бүсээс гаалийн нутаг дэвсгэрт оруулахад гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх зорчигчийн худалдан авсан 3.0 сая төгрөг хүртэл үнийн дүнтэй барааны нэр төрлийн жагсаалт”-ыг Шадар сайдын ажлын албатай хамтран боловсруулж батлуулсан.

2. Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн “Барилга хүлээн авах, дуусаагүй барилга шилжүүлэх тухай” 104 дүгээр тогтоолыг Шадар сайдын ажлын албатай хамтран батлуулж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн “Үндсэн хөрөнгө данснаас хасах, бүртгэх зөвшөөрөл олгох тухай” 451 дүгээр тогтоолын дагуу Алтанбулаг чөлөөт бүсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй дуусаагүй барилга/карказ/, биет бус хөрөнгөд бүртгэлтэй 1065м<sup>2</sup> газрыг данснаас хасаж, “Шинэ үндэс” ХХК-ны хөрөнгө оруулалтаар баригдсан конторын барилга, 397м<sup>2</sup> газрыг үндсэн хөрөнгөд бүртгэх ажлыг гүйцэтгэсэн.

3. Гаалийн ерөнхий газрын даргын 2020 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/102 дугаартай тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулж чөлөөт бүсэд зорчиж буй зорчигч Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 105 дугаартай тогтоолоор батлагдсан 3.0 сая төгрөг хүртэлх үнийн дүнтэй барааг чөлөөт бүсээс гаалийн нутаг дэвсгэрт оруулах, Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/223 дугаар тушаалаар баталсан “Зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлийг гаалийн хилээр нэвтрүүлэх журам”-ын 2.3.1-д заасан барааг зорчигч чөлөөт бүсээс хоногт нэгээс илүүгүй удаа гаалийн болон бусад татваргүйгээр гаалийн нутаг дэвсгэрт оруулах нөхцөл бүрдсэн.

4. 2008 оноос хойш чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт газар эзэмших эрх нь цуцлагдсан 231 аж ахуйн нэгжийн газрын төлбөрийн болох нийт 1.177.086.220 төгрөгийн үлдэгдэлтэй байсан бөгөөд 2018 оноос эхлэн шүүхийн байгууллагаар шийдвэрлүүлэхээр нэхэмжлэл гаргаж 2019 онд 809.898.660 төгрөг, 2020 оны 12 дугаар сарын байдлаар 423.999.170 төгрөг хүртэл тус тус бууруулан ажилласан байна.

## **1.2. Хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааг өргөжүүлэх.**

-Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын Засгийн газрын хоорондын комиссын ээлжит 23 дугаар хуралдаанд болон Бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааны Дэд комиссын 15 дугаар хуралдаануудад оруулах саналуудыг боловсруулан Шадар сайдын ажлын алба болон ГХЯ-нд хүргүүлсэн.

-Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техник, соёлын хамтын ажиллагааны Монгол, Казахстаны Засгийн газрын хоорондын комиссын ээлжит VIII хуралдаан, Монгол улс, БНСУ-ын Засгийн газар хоорондын хамтарсан хорооны V хуралдаан, Монгол, Европын холбооны хамтын ажиллагааны хамтарсан хорооны ХХ хуралдаануудад тус тус санал боловсруулан хүргүүлсэн.

-Монгол Улсад суугаа ОХУ-ын Худалдааны төлөөлөгчийн газар, Монгол-Оросын худалдааны танхим болон БНХАУ-ын ӨМӨЗО-ны Бизнесийн ерөнхий холбоо, “Зунхуа” нийгэмлэг, Баяннуур хотын Төлөөлөгчийн газар зэрэг байгууллагуудтай хамтын ажиллагаатай ажиллаж байна.

--Шадар сайдын Ажлын алба, МҮХАҮТ, Монгол Улсын гурван чөлөөт бүсүүдийн Захирагчийн ажлын алба, Хөрөнгө оруулагчдын нэгдсэн зөвлөл хамтран “Эдийн засгийн коридорт чөлөөт бүс холбогдох нь” эдийн засгийн форумыг зохион байгуулсан. Энэхүү арга хэмжээтэй холбогдуулан МУ-д чөлөөт бүсийг эрчимжүүлэх, хөгжүүлэх талаарх иргэдийн 500 гаруй гарын үсэгтэй шаардлага болон УИХ, Засгийн газарт хүргүүлэх шаардлагын эх бэлтгэл, мөн Үндэстний тойм” сэтгүүлд “Алтанбулаг” чөлөөт бүсийн тухай нийтлэл, он цагийн хэлхээс, ярилцлага зэрэг мэдээ мэдээллийг бэлтгэн боловсруулж удирдах дээд байгууллагад хүргүүлсэн.

-Сэлэнгэ аймгийн Засаг дарга Ш.Оргил, Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газрын дарга М.Дамдинхорол, Хилийн цэргийн 101 дүгээр ангийн Захирагч, хурандаа В.Намхайнямбуу нартай ажил хэргийн уулзалтуудыг зохион байгуулан тулгамдсан асуудлуудаа шийдвэрлэсэн.

-Хөрөнгө оруулагч ААН-үүдтэй 3 удаа уулзалтыг зохион байгуулж, цаг үеийн бүхий л асуудлаар сонсгол тавьж, санал бодлоо солилцон тулгамдаж буй шийдвэрлэх асуудлуудыг авч хэлэлцсэн.

-“Алтанбулаг” чөлөөт бүсийн үйл ажиллагааны тухай видео танилцуулга, 2D анимейшнийг хийж [www.altanbulag.gov.mn](http://www.altanbulag.gov.mn), [www.youtube.com](http://www.youtube.com) болон “Хөрөнгө оруулагчдын групп”, Сэлэнгэ аймаг, Алтанбулаг сумын ЗДТГ-ын веб сайт, фейсбук групп, Сэлэнгэ аймгийн ТВ сошиал сүлжээнүүдэд байршуулан, иргэдийн хандалтыг нэмэгдүүлсэн.

## ХОЁРДУГААР ХЭСЭГ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

### 2.1. Чөлөөт бүсийн дэд бүтэц, бүтээн байгуулалтын үйл ажиллагааг зохион байгуулах.

- 6.2 га худалдааны зам талбайн 2 дугаар талбайд шинээр суурилуулахаар төлөвлөсөн 0.4 кВ-ын хувиарлах самбар, шугам тоноглолын тооцоо судалгааг боловсруулж, бүсэд байнгын үйл ажиллагаа явуулж буй хөрөнгө оруулагч ААН-үүдийн хандивын хөрөнгөөр КТП- 405-аас 6.2 га зам талбайн цахилгааны тэжээлийн кабелийг солих, мөн бүсийн түр гарц руу тэжээлийн кабель шинээр татах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.
- Мөн 2015 онд чөлөөт бүсэд хийж гүйцэтгэсэн дэд бүтцийн ажил болох цэвэр усны хоолойн чигжээс гулгамтгай шавар хөрсний улмаас энэ жилийн борооны үерт идэгдэж гулсалт цөмрөлт үүссэнийг, Алтанбулаг сумын музейн болон сумын захиргааны зам дээр үүссэн нийт 200 метр орчим газарт асгаас хийж шаардлагатай арга хэмжээг авч ажилласан. /“Комфорт-Импекс”ХХК-тай хамтран/

*Чөлөөт бүсэд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн хөрөнгийн хадгаалалт, хамгаалалт, аж ахуйн үйлчилгээ зохион байгуулах.*


- Дэд бүтцийн тоног төхөөрөмжийн үйл ажиллагаа болон бүсийн хамгаалалтын хашааны бүрэн бүтэн байдалд үзлэг шалгалт хийж эвдрэл гэмтлийг тухай бүр засварлаж мөн бусад аж ахуй үйлчилгээг хийж гүйцэтгэсэн.
- Тохижилт үйлчилгээний чиглэлээр ногоон байгууламж байгуулсан.
- 2020 оны 02 дугаар сарын 25-ны өдөр Сэлэнгэ аймгийн онцгой байдлын комиссын шийдвэрээр чөлөөт бүсийн ШНБ-ыг ОХУ-аас дамжин орж ирэх иргэдийн түр тусгаарлах байр болгосон тул нүүлгэн шилжүүлж, бүсийн тасралтгүй хэвийн үйл ажиллагааг явуулах үүднээс түр гарц гаргаж, орох гарах чиглэлийн хөдөлгөөний зам гарган засварласан, Гаалийн байгууллага болон ХХБ-ын үйл ажиллагаа явуулахад шаардлагатай түр байрыг /тохижуулсан чингэлэг/ бэлдсэн. ШНБ-ыг 2020 оны 08 дугаар сард үргэлжүүлэн Алтанбулаг боомтын үйл ажиллагаа явуулах бүс буюу улаан бүс болгон ашиглаж байна.
- Байнгын үйл ажиллагаатай 22 аж ахуй нэгжүүдийн дэлгүүрүүдийн цахилгаан эрчим хүч, халаалтын системийг салгаж, хөлдөх магадлалтай барааг зөөвөрлөх зэрэг эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажилласан.

### 2.2. Чөлөөт бүсэд газар эзэмших, ашиглах зөвшөөрөл олгох.


- “Алтанбулаг” чөлөөт бүсийн “Үйлдвэрлэл”-ийн бүсэд 5 га хүртэл газар, “Худалдаа, үйлчилгээ”-ний бүсэд 1,2 га хүртэл газар, “Агуулах”-ын бүсэд 1 га хүртэл газар эзэмших, ашиглах хүсэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын дунд төсөл сонгон шалгаруулалтыг зарлаж 2020 оны 06 дугаар сарын 22-ны өдөр хүртэл төслүүдийг хүлээн авч мөн өдөр төслийн нээлтийг хийсэн.

## 2.3. Чөлөөт бүсийн зорчигч тээвэр, бараа эргэлтийн бүртгэлийн үйл ажиллагаа.

### ЗОРЧИГЧ, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН МЭДЭЭ /оноор/



### БАРАА ЭРГЭЛТИЙН МЭДЭЭ /оноор/



2020.02.27–2020.03.01- Захирагчийн захирамжаар  
 2020.03.01–2020.03.23- АОК-ын шийдвэрээр  
 2020.11.02 – тодорхойгүй хугацаагаар АОК-ын шийдвэрээр

### 3.1 Чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийг бүртгэх.

- 2015 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр Улсын бүртгэлийн газрын даргатай хамтран гаргасан тушаалын дагуу “Чөлөөт бүс” тодотгол олгох ажлын хүрээнд 17 аж ахуйн нэгжид бүртгэлийн гэрчилгээ олгосон.
- Газрын кадастрын мэдээллийн сангийн Лэнд менежер программын дагуу газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээг шинэчлэх ажлыг зохион байгуулж, нийт 70 гаруй аж ахуйн нэгжийн Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээг шинэчлээд байна.

### 3.2 Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангах.

- Байгууллагын бүтцийн дагуу төрийн захиргааны ахлах түшмэлийн 7 албан тушаал, дэс түшмэлийн 22 албан тушаал, нийт 29 албан тушаалын тодорхойлолтыг ТАЗ-ийн өгсөн заавар зөвлөмжийн дагуу боловсруулж, ТАЗ-ын 2020.04.01-ний 126, 127 дугаар тус тус тогтоолоор батлах зөвшөөрлийг олгосоны дагуу 2020 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн А/86 дугаар захирамжаар өөрийн байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг баталгаажуулан Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн.
- 2021-2024 оны Байгууллагын дунд хугацааны стратеги төлөвлөгөөг шинэчлэн боловсруулсан.
- Онц байдлын үед “Алтанбулаг” чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба нь Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын иргэдэд хүнсний барааны тусламж үзүүлэх ажлыг зохион байгуулж, байнгын үйл ажиллагаа явуулж буй хөрөнгө оруулагч ААН-үүдийн бүрдүүлсэн 4.150.000 /дөрвөн сая нэг зуун тавин мянган/ төгрөгийн хүнсний барааг Алтанбулаг сумын ЗДТГ-т гардуулан өгсөн. Энэхүү хүнсний тусламж нь зорилтод бүлгийн 50 өрхөд хүргэгдсэн бөгөөд 2 машин түлээг 4 айлд хүргэж өгсөн.
- Сум орон нутгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхээс гадна хариуцлагатай эргүүл, хяналтын цэгийн жижүүрийн үүргийг тус тус гүйцэтгэсэн. /2020 оны 11 дүгээр сарын 17,26,27,30-ны өдрүүд, 12 дугаар сарын 5,14,23-ны өдрүүдэд /
- -ГХЯ-ны Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газар, Хөрөнгө оруулалтын судалгааны төвөөс НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисстой хамтран зохион байгуулсан “Эдийн засгийн коридорын үр ашигтай менежментээр Зүүн болон Зүүн Хойд Азийн дэд бүсийн харилцан холбоог бэхжүүлэх тухай” багц сургалтанд 2 удаа хамрагдаж идэвхтэй оролцсон.

### 3.3 Төсөв, санхүүгийн үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, зохицуулах.

- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан Алтанбулаг чөлөөт бүсийн цахилгаан хангамжийн өргөтгөл, ашиглалтын төсөв 15,6 тэрбум төгрөг, мөн Гаалийн теле хяналтын нэгдсэн системийн ажлын нийт санхүүжилт болох 130.0 сая төгрөгийг 2022 оны хөрөнгө оруулалтын төсөвт суулгуулахаар саналаа хүргүүлсэн.
- 2020 онд улсын төсөвт төвлөрүүлсэн нийт орлого: 98,948,218 төгрөг
- Газрын төлбөрт нийт 83,959,668 төгрөг;
- Төсөл сонгон шалгаруулалтын анхны үнэ- 11,520,000 төгрөг;
- Тусгай зөвшөөрлийн хураамж ба бусад – 3,468,550 төгрөг